



СЭЛЭНГЭ АЙМАГ
САНТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 09 сарын 06 өдөр

Дугаар 447

Цагаантолгой

Тендер шалгаруулалтын ажлын
хэсэг байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.23, Төрийн болон Орон нутгийн өмч хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2, 7 дугаар зүйлийн 7.1.1, 31 дүгээр зүйлийн 31.1.2, 33 дугаар зүйлийг тус тус үндэслэн
ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын “Цэцэрлэгийн хүүхдийн өдрийн хоол”-нд худалдан авалт хийх тендер шалгаруулалтын ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч- Б.Мөнх-Эрдэнэ- (сумын Засаг даргын орлогч)

Нарийн бичиг- 3.Оюунсүрэн- (Жижиг дунд үйлдвэрлэл, худалдаа, хоршоо хариуцсан мэргэжилтэн)


Гишүүд- Ж.Оюунбат- (Архив, бичиг хэргийн эрхлэгч)

А.Батдорж- (Байгаль орчны хяналтын улсын байцаагч)

Ч.Төгсбаатар- (Хушаат багийн байгаль хамгаалагч)

2. Тендер шалгаруулалтын ажлыг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулж явц үр дүнгийн талаар танилцуулж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Б.Мөнх-Эрдэнэ)-д даалгасугай.

3. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (А.Одхүү)-д үүрэг болгосугай.



С.ШИЖИРБААТАР

Боловсруулсан: Занданцэрэг

Хянасан: Ч.Доржсүрэн

Хувь: 2

Санал: 10.07.2026